

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/21/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Арвайхээр
2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Аудитор: Р.Энхзул

Утас: 70323833 Цахим хаяг: EnkhzulR@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

- 1. Аудитын санал дүгнэлт
- 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
- 3. Аудитын тайлан

 - 3.1 Ерөнхий зүйл
 - 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Материаллаг байдал
 - 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга
 - 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
 - 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
 - 3.8 Аудитын гол асуудал
 - 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- 4. Аудитын илрүүлэлт
- 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.01.24 № 225
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ
АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА
С.ЦЭДЭНБАЛЖИР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

015030460

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,070,843.88	29,291,298.88
33	АВЛАГА	3,648,386.00	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,648,386.00	-
34	УРЬДЧИЛГАА	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	21,422,457.88	22,091,298.88
351	Түүхий эд материал	-	330,000.00
35110	Тусгай зориулалттай материал	-	330,000.00
354	Хангамжийн материал	20,432,457.88	20,771,298.88
35410	Бичиг хэргийн материал	1,537,600.00	440,000.00
35420	Аж ахуйн материал	5,820,300.39	5,700,300.39
35430	Сэлбэг хэрэгсэл	2,525,000.00	3,125,000.00
35470	Бусад хангамжийн материал	10,549,557.49	11,505,998.49
35600	Мал амьтад	990,000.00	990,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	254,804,417.95	229,599,114.56
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	254,804,417.95	229,599,114.56
392	Биет хөрөнгө	135,357,584.59	111,531,614.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	10,380,387.86	10,380,387.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,570,157.72)	(4,421,436.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	254,005,985.52	254,005,985.52
39204	Хуримтлагдсан элэгдэл	(177,252,997.76)	(207,281,341.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,627,536.34	107,399,336.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	(57,361,192.81)	(70,425,350.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,526,359.91	48,814,569.91
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,998,336.75)	(26,940,536.36)
393	Биет бус хөрөнгө	119,446,833.36	118,067,500.08
39301	Програм хангамж	7,350,000.00	7,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,178,166.64)	(3,557,499.92)
39303	Бусад биет бус хөрөнгө	114,275,000.00	114,275,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	279,875,261.83	258,890,413.44
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	279,875,261.83	258,890,413.44
51	Засгийн газрын хувь оролцоо	279,875,261.83	258,890,413.44
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	854,894,694.55	854,894,694.55
51101	Өмч: - төрийн	854,894,694.55	854,894,694.55
512	Хуримтлагдсан үр дүн	(687,668,396.93)	(708,653,245.32)
51210	Өмнөх үеийн үр дүн	(573,286,513.60)	(687,668,396.93)
51220	Тайлант үеийн үр дүн	(114,381,883.33)	(20,984,848.39)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	112,648,964.21	112,648,964.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	279,875,261.83	258,890,413.44

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,390,068,511.24	927,168,509.64
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	678,163,853.24	225,128,135.64
120	Нийтлэг татварын бус орлого	678,163,853.24	225,128,135.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	678,163,853.24	225,128,135.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,445,500.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		21,094,010.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	676,718,353.24	204,034,125.64
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	711,904,658.00	702,040,374.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	451,716,600.00	388,636,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	451,716,600.00	388,636,200.00

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	260,188,058.00	313,404,174.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив,	82,827,850.00	82,951,350.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	175,710,208.00	230,052,824.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,650,000.00	400,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,504,450,394.57	748,153,358.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,504,450,394.57	748,153,358.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,490,668,130.57	746,807,601.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,026,100.00	232,726,357.00
210101	Үндсэн цалин	152,077,100.00	185,166,800.00
210102	Нэмэгдэл	31,254,719.00	41,446,697.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,694,281.00	6,112,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,303,600.00	30,120,700.00
210201	Тэтгэврийн даатгал	17,102,400.00	21,196,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,800,200.00	2,231,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,440,300.00	1,784,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	360,100.00	446,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,600,600.00	4,462,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,252,700.00	9,257,700.00
210301	Гэрэл, цахилгаан	150,000.00	-
210302	Түлш, халаалт	-	155,000.00
210304	Байрны түрээс	9,102,700.00	9,102,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,198,506.00	27,242,857.70
210401	Бичиг хэрэг	3,592,300.00	4,116,850.00
210402	Тээвэр, шатахуун	15,346,706.00	13,085,930.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,792,000.00	2,270,077.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,467,500.00	7,770,000.00
2105	Нормативт зардал	-	396,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	396,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,273,900.00	3,349,600.00
210604	Урсгал засвар	3,273,900.00	3,349,600.00
2107	Томилолт, зочны зардал	4,485,500.00	3,209,200.00
210702	Дотоод албан томилолт	4,485,500.00	3,209,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	188,675,736.00	80,203,189.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	186,785,246.00	75,713,789.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	409,900.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	659,700.00	527,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	301,700.00	271,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	113,000.00	90,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	6,190.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,042,452,088.57	360,301,898.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	991,112,225.62	310,036,584.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,339,862.95	50,265,313.39
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,782,264.00	1,345,756.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,257,600.00	492,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,642,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	615,000.00	492,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	524,664.00	853,756.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	524,664.00	853,756.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(114,381,883.33)	179,015,151.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	200,000,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	200,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(200,000,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(114,381,883.33)	(20,984,848.39)

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	854,894,694.55	112,648,964.21	-573,286,513.60	0.00	394,257,145.16
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	854,894,694.55	112,648,964.21	-573,286,513.60	0.00	394,257,145.16
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-114,381,883.33	0.00	-114,381,883.33
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	854,894,694.55	112,648,964.21	-687,668,396.93	0.00	279,875,261.83
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	854,894,694.55	112,648,964.21	-687,668,396.93	0.00	279,875,261.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	854,894,694.55	112,648,964.21	-687,668,396.93	0.00	279,875,261.83
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	854,894,694.55	112,648,964.21	-687,668,396.93	0.00	279,875,261.83
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-20,984,848.39	0.00	-20,984,848.39
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	854,894,694.55	112,648,964.21	-708,653,245.32	0.00	258,890,413.44

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	713,350,158.00	705,688,760.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,445,500.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,445,500.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,445,500.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,445,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	711,904,658.00	705,688,760.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	451,716,600.00	388,636,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	451,716,600.00	388,636,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	260,188,058.00	317,052,560.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	82,827,850.00	82,951,350.00
131103	ЗГНХ ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	175,710,208.00	230,052,824.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,648,386.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,650,000.00	400,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	712,250,158.00	701,722,760.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	712,250,158.00	701,722,760.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	694,819,508.00	700,377,003.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,026,100.00	232,726,357.00
210101	Үндсэн цалин	152,077,100.00	185,166,800.00
210102	Нэмэгдэл	31,254,719.00	41,446,697.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,694,281.00	6,112,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,303,600.00	30,120,700.00
210201	Тэтгэврийн даатгал	17,102,400.00	21,196,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,800,200.00	2,231,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,440,300.00	1,784,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	360,100.00	446,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,600,600.00	4,462,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,252,700.00	9,257,700.00
210301	Гэрэл, цахилгаан	150,000.00	-
210302	Тулш, халаалт	-	155,000.00
210304	Байрны түрээс	9,102,700.00	9,102,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,526,600.00	11,156,577.70
210401	Бичиг хэрэг	2,525,300.00	1,560,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,980,400.00	7,118,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,792,000.00	2,270,077.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	228,900.00	208,100.00
2105	Нормативт зардал	196,100.00	196,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	196,100.00	196,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,839,600.00	6,274,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	329,600.00	263,700.00
210604	Урсгал засвар	4,510,000.00	6,010,800.00

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	4,485,500.00	3,209,200.00
210702	Дотоод албан томилолт	4,485,500.00	3,209,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	191,649,636.00	89,703,309.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	189,759,146.00	78,013,909.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	409,900.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	659,700.00	527,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	301,700.00	271,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	113,000.00	90,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	6,190.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	256,539,672.00	317,732,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	256,539,672.00	317,732,560.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,430,650.00	1,345,756.30
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,257,600.00	492,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,642,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	615,000.00	492,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,173,050.00	853,756.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,173,050.00	853,756.30
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,100,000.00	3,966,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,100,000.00	3,966,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,100,000.00	3,966,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,100,000.00	3,966,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,100,000.00	3,966,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,100,000.00)	(3,966,000.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	452,716,600.00	452,637,436.00	388,636,200.00	387,782,443.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,716,600.00	452,637,436.00	388,636,200.00	387,782,443.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	439,459,000.00	439,379,836.00	388,144,200.00	387,290,443.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	190,026,100.00	190,026,100.00	233,115,800.00	232,726,357.00
210101	Үндсэн цалин	152,077,100.00	152,077,100.00	185,166,800.00	185,166,800.00
210102	Нэмэгдэл	32,192,800.00	31,254,719.00	42,192,800.00	41,446,697.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,756,200.00	6,694,281.00	5,756,200.00	6,112,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,303,600.00	24,303,600.00	30,120,700.00	30,120,700.00
210201	Тэтгэврийн даатгал	17,102,400.00	17,102,400.00	21,196,000.00	21,196,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,800,200.00	1,800,200.00	2,231,200.00	2,231,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,440,300.00	1,440,300.00	1,784,900.00	1,784,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	360,100.00	360,100.00	446,300.00	446,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,600,600.00	3,600,600.00	4,462,300.00	4,462,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,252,700.00	9,252,700.00	9,683,300.00	9,257,700.00
210301	Гэрэл, цахилгаан	150,000.00	150,000.00	353,600.00	-
210302	Түлш, халаалт	-	-	155,000.00	155,000.00
210303	Цэвэр, бохир ус	-	-	72,000.00	-
210304	Байрны түрээс	9,102,700.00	9,102,700.00	9,102,700.00	9,102,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,526,600.00	13,526,600.00	11,156,800.00	11,156,577.70
210401	Бичиг хэрэг	2,525,300.00	2,525,300.00	1,559,400.00	1,560,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,980,400.00	8,980,400.00	7,119,200.00	7,118,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,792,000.00	1,792,000.00	2,270,100.00	2,270,077.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	228,900.00	228,900.00	208,100.00	208,100.00
2105	Нормативт зардал	196,100.00	196,100.00	196,100.00	196,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	196,100.00	196,100.00	196,100.00	196,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,839,600.00	4,839,600.00	6,274,500.00	6,274,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	329,600.00	329,600.00	263,700.00	263,700.00
210604	Урсгал засвар	4,510,000.00	4,510,000.00	6,010,800.00	6,010,800.00
2107	Томилолт, зочны зардал	4,485,500.00	4,485,500.00	3,209,200.00	3,209,200.00
210702	Дотоод албан томилолт	4,485,500.00	4,485,500.00	3,209,200.00	3,209,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	192,828,800.00	192,749,636.00	90,137,800.00	90,099,309.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчил	189,759,200.00	189,759,146.00	78,410,000.00	78,409,909.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	409,900.00	409,900.00	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	659,700.00	659,700.00	527,800.00	527,800.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	339,000.00	301,700.00	271,200.00	271,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	113,000.00	113,000.00	90,400.00	90,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	10,800,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	48,000.00	6,190.00	38,400.00	-

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	4,250,000.00	4,250,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	4,250,000.00	4,250,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,257,600.00	13,257,600.00	492,000.00	492,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,257,600.00	13,257,600.00	492,000.00	492,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,642,600.00	12,642,600.00	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	615,000.00	615,000.00	492,000.00	492,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	451,716,600.00	451,716,600.00	388,636,200.00	388,636,200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	451,716,600.00	451,716,600.00	388,636,200.00	388,636,200.00
122005	Орон нутгийн төсвөөс	451,716,600.00	451,716,600.00	388,636,200.00	388,636,200.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	256,539,672.00	317,052,560.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	256,539,672.00	317,052,560.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	256,539,672.00	317,052,560.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	256,539,672.00	317,052,560.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	256,539,672.00	317,052,560.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	260,188,058.00	317,052,560.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	260,188,058.00	317,052,560.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	82,827,850.00	82,951,350.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	175,710,208.00	230,052,824.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,648,386.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,650,000.00	400,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Р.Энхзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймгийн Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 26 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь 2021 онд “Салбарын бодлогыг орон нутагт оновчтой хэрэгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, хүн амыг аюулгүй хүнсээр хангах” зорилго тавьсан бөгөөд “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарыг тогтвортой хөгжүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хангаж,

дотоод гадаадын зах зээлд өрсөлдөх, байгаль, эдийн засгийн эрсдэл даах чадавхтай уламжлалт болон эрчимжсэн хөдөө аж ахуй, дэвшилтэт техник, технологи бүхий хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарыг орон нутагт төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Байгууллагын дотоод хяналтын нэгж нь 1 орон тоотой бөгөөд хяналт, шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн хариуцан ажиллаж байна. ХХААХҮСайдын хяналт шинжилгээ үнэлгээ тухай 159 дүгээр тушаалыг мөрдөн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тухайн онд хийж хэрэгжүүлэх ажлаа тусган нэгжийн даргаар батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2021 онд 7 сумын Хөдөө аж ахуйн тасгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, илрүүлсэн алдаа зөрчлийг арилгуулах зөвлөмжийг хүргүүлсэн, зөвлөмжийн хэрэгжилтийг газар дээр нь очиж дахин шалгах ажил хийгдээгүй 2022 онд багтаан зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахар төлөвлөгдсөн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 748212.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 7482.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 5985.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдал аудитын явцад нийт зардалд өөрчлөлт орсноос 7481.5 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө болон бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 25060.0 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан 3966.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ХХААХҮС-ын тушаалаар шилжиж ирсэн 21094.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Бараа материал оны эхнээс 668.8 мянган төгрөгөөр өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 387188.4 мянган төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 281284.1 мянган төгрөгөөр батлагджээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 281284.1 мянган төгрөгөөр батлагдаж, тодотголоор 107352.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 388636.2 мянган төгрөгийн санхүүжилт ирсэн ба үүнээс 853.7 мянган төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Тайлант оны нийт төсвийн гүйцэтгэл 387782.5 мянган төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөцөөс 230052.8 мянган төгрөгийг, дээд шатны төсвийн захирагчаас 3648.4 мянган төгрөгийг, хандив тусламжаар 82951.3 мянган төгрөгийг, нэмэлт орлогоор 400.0 мянган төгрөгийг нийт 317052.6 мянган төгрөгийг санхүүжүүлэн бараа үйлчилгээний бусад зардалд 317052.6 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэхэд шинээр 320.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан зөрчил илэрлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар нь шилэн дансны цахим хуудсанд нийт 149 мэдээлэл байршуулахаас 140 мэдээллийг хугацаанд нь, хугацаа болоогүй 4 мэдээлэл, 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой

байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 320.0 мянган төгрөгийн алдаа илэрсэн.

4.1 Залруулга

Залруулга байхгүй

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Шинээр 320.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан зөрчилд албан шаардлага өгсөн.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар	1	320.0					1	320.0		

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

Д.ГАНСҮХ

Р.ЭНХЗУЛ